



ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ 2026 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН АЖЛЫН  
ТАЙЛАН Б.БАТТУШИГ

2026 оны 04 сарын 15  
Улаанбаатар хот

Тээвэр хөгжлийн банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Б.Баттүшиг миний бие 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн тус банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний хувьд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Компанийн тухай хууль, Банкны тухай хууль” болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Банкны Зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”, “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, Тээвэр хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон Банкны Дүрмийг тус тус мөрдөж хэрэгжүүлэн ажилласан болно.

### **Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцсон байдал**

Банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь 2026 оны 01 дүгээр улирал буюу 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд 3 удаа хуралдаж нийт 10 асуудлыг хэлэлцсэн бөгөөд дараах асуудлуудыг шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцсон болно. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн **2026 оны 01 сарын 08-ны өдрийн №Т/26-01** дугаартай хурлаар:

1. Банкны дотоод аудитын газрын аудиторуудыг банкны үндсэн ажилтнаар томилох тухай хэлэлцэж, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны хурлын санал, дүгнэлтийг болон аудиторуудын туршилтын хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг тус тус үндэслэн [REDACTED] 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн дотоод аудитын газрын ерөнхий аудитын хэлтсийн аудитор албан тушаалд үндсэн ажилтнаар томилох, мөн [REDACTED] овогтой [REDACTED] 2026 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн дотоод аудитын газрын мэдээллийн технологийн аудитор албан тушаалд үндсэн ажилтнаар томилохоор тус тус шийдвэрлэсэн бөгөөд дээрх асуудлын хүрээнд саналын хуудсаар өөрийн саналыг баталгаажуулсан болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн **2026 оны 02 сарын 11-ний өдрийн №Т/26-02** дугаартай хурлаар:

1. Банкны 2025 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогын дагуу хөрөнгө актлах тухай
2. Банкны өмчлөлийн тээврийн хэрэгслийг худалдах саналыг хэлэлцэх тухай
3. Банкны өмчлөлийн биет бус хөрөнгө болох гар утасны дугаарыг шилжүүлэх саналыг хэлэлцэх тухай

4. Банкны хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит болон ээлжит бус хурлуудыг тус тус зарлан хуралдуулах тогтоолын төслийг хэлэлцэх тухай

Дээрх асуудлын хүрээнд хуралд саналын эрхтэй оролцож тус хурлаас дараах шийдвэрүүдийг гарган ажилласан. Үүнд:

- Тээвэр хөгжлийн банкны 2025 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогын дагуу нийт [REDACTED] [REDACTED] төгрөгийн үлдэх өртөг бүхий энэхүү тогтоолын хавсралт №1-д заасан 181 ширхэг биет болон биет бус хөрөнгийг актлахыг дэмжиж, тус асуудлыг банкны хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.
- Банкны өмчлөлийн [REDACTED] улсын дугаартай “TESLA X” маркийн тээврийн хэрэгслийг өмнө нь гарч байсан томоохон засвар үйлчилгээ, цаашид техникийн эвдрэл гэмтэл гарч болзошгүйг харгалзаж үлдэх өртөг болох [REDACTED] [REDACTED] төгрөгөөр худалдах, заасан үнийн дүнгээр худалдах боломжгүй тохиолдолд үлдэх өртгийг 30 /гуч/ хүртэлх хувиар бууруулан худалдах тухай саналыг дэмжиж, энэхүү асуудлыг банкны хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.
- Банкны өмчлөлийн биет бус хөрөнгөд бүртгэлтэй [REDACTED] тоот гар утасны дугаарыг үлдэх өртөг болох [REDACTED] [REDACTED] төгрөгөөр тооцож [REDACTED] д шилжүүлэх тухай саналыг дэмжиж, тус асуудлыг банкны хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.
- Тээвэр хөгжлийн банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 15 цаг 00 минутад банкны төв байрны 15 давхарт зарлан товлон. Ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэв. Үүнд: Банкны өмчлөлийн эд хөрөнгийг худалдах саналыг хэлэлцүүлэх тухай; Банкны 2025 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогын дагуу хөрөнгө актлах саналыг хэлэлцэх тухай; Банкны өмчлөлийн биет бус хөрөнгийг шилжүүлэх асуудлыг хэлэлцэх тухай; Банкны хувьцаа эзэмшигчдийн [REDACTED] [REDACTED] байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний хугацааны талаарх асуудлыг хэлэлцүүлэх тухай

- Тээвэр хөгжлийн банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлыг 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 14:00 цагт банкны 15 давхрын хурлын танхимд зарлан товлов. Ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэв. Үүнд: Банкны 2025 оны жилийн тайлангийн талаарх танилцуулга; Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулга; Активыг холбогдох сангаас хаасан болон активыг тэнцлээс хассан талаарх тайлангийн танилцуулга; Банкны 2025 оны хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах; Банкны 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай
- Тээвэр хөгжлийн банк ХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт, татварын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайланг тус тус Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулахыг банкны Гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбаяр/-д үүрэг болгосон ба дээрх асуудлуудад өөрийн саналыг саналын хуудсаар албажуулсан болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн **2026 оны 03 сарын 27-ны өдрийн №Т/26-03** дугаартай хурлаар:

1. Банкны Комплаенсийн үйл ажиллагааны тайлан танилцуулах тухай
2. Банкны “Комплаенсийн бодлого” шинэчлэн батлах тухай
3. Банкны “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх бодлого” шинэчлэн батлах тухай
4. Банкны “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр” шинэчлэн батлах тухай

Дээрх бодлогын баримт бичиг батлах асуудлын хүрээнд

- Банкны Комплаенсийн 2026 оны 01 дүгээр улирлын үйл ажиллагааны тайлантай танилцаж, холбогдох санал, зөвлөмжийг өгөв.

- Банкны Комплаенсийн бодлогыг хавсралтаар шинэчлэн баталж, тогтоол батлагдсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгов.

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийг хавсралтаар шинэчлэн баталсан бөгөөд Мөнгө угаах, терроризмыг

санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий албан тушаалтнаар Комплаенсийн газрын захирал (Э.Батчулуун)-г томилохоор шийдвэрлэв.

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх бодлогыг хавсралтаар шинэчлэн баталж, тогтоол батлагдсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгов.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дээрх хурлуудад миний бие оролцож, хараат бус гишүүний зүгээс зохих санал дүгнэлтийг тухай бүр гарган оролцож, саналын зөрүүтэй асуудал байгаагүй болно.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны  
хуралд оролцсон байдал /2026 оны 01 дүгээр улирлын байдлаар/**

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь 2026 оны 01 дүгээр улирлын байдлаар 1 удаа хуралдсан бөгөөд тус хурлуудаар нийт 4 асуудлыг хэлэлцэж дараах санал, дүгнэлтийг гаргаж ажилласан. Үүнд:

Эрсдэлийн удирдлагын хорооны **2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн №ЭУХ/26-01** дугаартай хурлаар:

1. Банкны Комплаенсийн үйл ажиллагааны тайлан танилцуулах тухай /1 дүгээр улирлын байдлаарх танилцуулга/
2. Банкны Комплаенсийн бодлогыг шинэчлэн батлах тухай
3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх бодлого шинэчлэн батлах тухай
4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай

Дээрх асуудлын хүрээнд хорооны хурлаас дараах санал, дүгнэлтийг гарган ажилласан. Үүнд:

1. Банкны Комплаенсийн 2026 оны 01 дүгээр улирлын үйл ажиллагааны тайлантай танилцаж, холбогдох санал, зөвлөмжийг өгөв.
2. Банкны Комплаенсийн бодлогыг хавсралтаар шинэчлэн батлах саналтайгаар дэмжиж, хорооны хурлаас гарсан санал, дүгнэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулахаар шийдвэрлэсэн.
3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийг хавсралтаар шинэчлэн батлахыг дэмжсэн бөгөөд Мөнгө угаах,

терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий албан тушаалтнаар Комплаенсийн газрын захирал (Э.Батчулуун)-г томилохоор шийдвэрлэсэн саналыг тус тус Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх бодлогыг хавсралтаар шинэчлэн батлах саналыг дэмжиж, хорооны хурлаас гарсан санал, дүгнэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

### **Сонирхлын зөрчилтэй хэлцэл ба их хэмжээний хэлцлийн тайлан**

Монгол Улсын Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгнө гэж заасан.

Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар нэг асуудлыг хэлэлцсэн ба Гүйцэтгэх захирлаас ирүүлсэн банкны холбогдох этгээд болох [REDACTED] [REDACTED] банкны өмчлөлийн биет бус хөрөнгөд бүртгэлтэй гар утасны дугаарыг үлдэх өртгөөр тооцож, шилжүүлэх тухай Эд хөрөнгө шилжүүлэх гэрээ байгуулахтай холбоотой ирүүлсэн баримт бичигтэй танилцан дараах санал, зөвлөмжийг гаргасан. Үүнд:

1. “Тээвэр хөгжлийн банк” ХК нь [REDACTED] [REDACTED]-тэй банкны өмчлөлийн биет бус хөрөнгөд бүртгэлтэй [REDACTED] тоот гар утасны дугаарыг үлдэх өртөг болох [REDACTED] [REDACTED]-өөр тооцож, шилжүүлэх тухай Эд хөрөнгө шилжүүлэх гэрээ байгуулагдахаар байгаа ба танилцуулгад зааснаар [REDACTED] нь Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2.д дэх заалтад заасны дагуу банкны холбогдох этгээд байна.
2. Гэвч дараах үндэслэлээр энэхүү гэрээг байгуулах нь холбогдох хууль, тогтоомжид нийцнэ гэж үзэж байна:
  - а. [REDACTED] байгуулах гэрээний агуулга нь банкны өмчлөлийн биет бус хөрөнгөд бүртгэлтэй гар утасны дугаарыг үлдэх өртгөөр шилжүүлэх тухай байх тул эрх зүйн зарчимд харшлаагүй байна.
  - б. [REDACTED] [REDACTED] байгуулах гэрээ нь Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйд заасны дагуу сонирхлын

